

## “Монгео” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайлан

Компани тайлант хугацаанд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Компанийн тухай хууль” болон бусад хуулиуд, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Хөрөнгийн Биржээс баталсан журам, үүрэг даалгавар компанийн дүрэм, дотоод журам , компанийн 2020 онд хуралдсан Хувь нийлүүлэгчдийн хурлаас гарсан шийдвэр болон ТУЗ-ийн хурлын шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллах зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

“Монгео” ХК нь “Үнэт цаас хадгаламжийн төв” ХХК-тай үнэт цаасны хадгаламжийн гэрээг хугацаанд нь байгуулан төлбөр тооцоог төлж хамтран ажиллаж байна.

Тус компанийн удирдах байгууллага Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржтэй хамтран ажиллаж тэдгээр байгууллагуудаас ирүүлсэн албан тоот, удирдамжыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллалаа. Орон тооны хувьд компани 8 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

Монгол улсын засгийн газраас гаргасан улс орны өндөржүүлсэн бэлэн байдлыг бууруулах хүртэл хугацаанд хөл хорионы дэглэм болон халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажилласан болно. Компанийн ажиллагсад өөрсдийн ажил үүргийн дагуу ажил үүргээ гүйцэтгэж ирлээ.

Хэдийгээр компани өөрийн үндсэн үйл ажиллагааны геологийн, хайгуулын бүх төрлийн ажил , газар тариалан , гадаад, дотоод худалдаа, аялал жуулчлал, иргэний болон үйлдвэрлэлийн барилга угсралтын зураг төсөл боловсруулах, угсралт хийх , геодези зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулаагүй байгаа ч өөрийн эзэмшлийн барилгын өрөөнүүдийг аж ахуй нэгж болон иргэдэд түрээслүүлэн салбар салбарын хүмүүст ажлын байр бий болгох үйл ажиллагааг явуулж байна.

2021 онд компанийн барилгын 12-173 мкв бүхий өрөөнүүдийг үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар 11 аж ахуй нэгж, 3 иргэнтэй түрээсийн гэрээ байгуулж ажилласан байна.

Сар бүр компанийн санхүүд бүрэлдэх түрээсийн орлогыг цаг хугацаанд нь төвлөрүүлж нийт ажиллагсдын цалин урамшуулал, НДШ , бүх төрлийн татварыг бүхий л боломжоороо төлөх, мөн сар тутмын хэрэглээний цахилгаан, дулаан , халуун хүйтэн усны төлбөр, хог хаягдлын төлбөрийг төлж барагдуулахад зарцуулж байна. 2021 онд эдгээр төлбөрийн үлдэгдэл өргүй байна.

Тус компанийн эзэмшлийн СХД болон ХУД-т байрлал бүхий 4303 мкв, 8.08 га газруудын жилийн төлбөрийн үлдэгдэлгүй байгаа нь сайшаалтай. Тайлант хугацаанд

компани түрээсийн орлогоос /80,328.6/ төгрөг төвлөрүүлж , өөрийн үйл ажиллагаатай холбогдол бүхий зардлуудыг төлж барагдуулан ажилласан болно.

Бидний төвлөрүүлж буй түрээсийн орлого маань олон жилээр хуримтлагдсан олон төрлийн татварын өрийг гүйцэт төлж барагдуулахад хүрэлцэхгүй, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж чадахгүй байгаа зэргээс хамааран ашигтай бус алдагдалтай ажиллаж байгаа билээ.

Иймээс хувь нийлүүлэгчдэд ногдол ашиг хуваарилж чадахгүй байгаа юм. Өнгөрсөн 2021 онд компани санхүү татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн татварын тайлангуудыг хуулинд заасан цаг хугацаанд нь тайлагнан холбогдох байгуулагуудад хүргэж хоцрогдол ,алдангигүй ажилласан байна. Бид 2021 онд цахилгаан, ус, дулаан , хог хаягдлын болон НДШ-ийн өргүй ажиллалаа.

Компанийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн шаардлага хангасан тусгай зөвшөөрөлтөй “Гэрэлт Хөхийн Тэнцвэр Аудит “ ХХК-тай гэрээ үйлдэн жилийн санхүүгийн тайланд аудит хийлгэн дүгнэлт үйлдүүлсэн болно.

Өнгөрсөн оны хувьд Хувь Нийлүүлэгчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэрүүдийг зохих түвшинд хангаж ажилласан байна.

Тайлант хугацаанд хуримтлагдсан байсан НӨАТ-ын /4,544.1/ төгрөгийг , ХАОАТ-ын /3,716.3/төгрөгийг ,ҮХЭХАТ-ын /1,294.0/төгрөгийг төлж барагдуулсан байна.

Цаашид ХУД-ийн 12- р хорооны нутаг дэвсгэрт байрлал бүхий 8,08 га газрыг зөв зохистой ашиглах төсөл ,төлөвлөгөө боловсруулж төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг эхлүүлэх зорилт тавин ажиллах болно.

Хувь Нийлүүлэгчдийн хурлаас гарах шийдвэрүүдийг хүндэтгэн үзэж, хүлээн авч компанийн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллах шаардлагыг ханган, үр дүнг тооцож ажиллах болно.

Компанийн Захиргаа